



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "д" заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалт, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн "Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нарт даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүрийн эцэст дүүргийн Засаг даргад үр дүнг тайлагнаж ажиллахыг Засаг даргын Инноваци, хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Х.Алтаншагай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.БАТСҮМБЭРЭЛ

115020000308



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүүрийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Хөрөнгийн эх үүсвэр	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)								Хэрэгжүүлэх байгууллага		
								2021 он		2022 он		2023 он		2024 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
								Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв									
НЭГ. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО																		
1.1. "Ковид-19" халдварт цар тахлын халдвар болон мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, дүүргийн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, иргэдийн эрүүл аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулана.	1	1.1.1. Дүүргийн хэмжээнд халдваргүйжүүлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагууд, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийн судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангуулах. Халдваргүйжүүлэлтийн үр дүнг үнэлэх, халдваргүйжүүлэлтийн бодис, ажлын уусмалын чанар, аюулгүй байдалд шинжилгээтэй хяналт хийх, зөвлөн туслана.	Цар тахлын бэлэн байдлын үед	2.0	Улсын төсөв	Хувь	2020 онд зөвлөн туслах үйлчилгээнд хамруулахаар төлөвлөсөн объектуудыг 100% хамруулсан.	100% Хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн байна. Халдваргүйжүүлэлт ийн бодис, ажлын уусмалын үр дүнг үнэлсэн байна.	0,5	100% Хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн байна. Халдваргүйжүүлэлт ийн бодис, ажлын уусмалын үр дүнг үнэлсэн байна.	0,5	100% Хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн байна. Халдваргүйжүүлэлт ийн бодис, ажлын уусмалын үр дүнг үнэлсэн байна.	0,5	100% Хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн байна. Халдваргүйжүүлэлт ийн бодис, ажлын уусмалын үр дүнг үнэлсэн байна.	0,5	МХХ	ЭМТ	
	2	1.1.2. Тархвар зүйн зургалганы дагуу болон голломтын эцсийн халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Цар тахлын бэлэн байдлын үед	21.0	Улсын төсөв	Хувь	ЗӨСҮТ-өөс 21 газарт хийгдсэн голломтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж ажиллалаа. Халдваргүйжүүлэлтийн явцад Хлорсефт-17 нэрийн бодисын 0.06 %-ийн ажлын уусмалаар халдваргүйтэлийг мананцар үүсгэж нийт 19946м2 талбайд халдваргүйжүүлэлтийг хийсэн.	100% Халдваргүйжүүлэлт ийн үр дүнг үнэлнэ. Бэлэн байдал хангагдана.	7.0	100% Халдваргүйжүүлэлт ийн үр дүнг үнэлнэ. Бэлэн байдал хангагдана.	7.0	100% Халдваргүйжүүлэлт ийн үр дүнг үнэлнэ. Бэлэн байдал хангагдана.	7.0	100% Халдваргүйжүүлэлт ийн үр дүнг үнэлнэ. Бэлэн байдал хангагдана.	7.0	МХХ	ЭМТ	
	3	1.1.3. Тусгаарлах байруудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, голломтын болон байнгын халдваргүйжүүлэлтийн үр дүнг үнэлэх, халдваргүйжүүлэлтийн бодис, ажлын уусмалын чанар, аюулгүй байдалд шинжилгээтэй хяналт хийх, зөвлөн туслана.	Цар тахлын бэлэн байдлын үед	8.0	Улсын төсөв	Хувь	Тусгаарлагдах хугацаанд тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэж буй ажилтан, албан хаагч нартай онлайнаар холбогдон, камерын хяналт тавьж тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.	100% Тусгаарлах байруудын үйл ажиллагаа сайжирч зөрчлийн хувь буурсан байна.	2.0	100% Тусгаарлах байруудын үйл ажиллагаа сайжирч зөрчлийн хувь буурсан байна.	2.0	100% Тусгаарлах байруудын үйл ажиллагаа сайжирч зөрчлийн хувь буурсан байна.	2.0	Цэгүүдэд ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийлгүүлж, гадна орчинд хүн хоорондын зай баруулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх	2.0	МХХ	ЭМТ	
	4	1.1.4. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт заагдсан байршилд шинжилгээ авах цэгүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж шинжилгээ авах байруудыг бэлдүүлж, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллана.	Цар тахлын бэлэн байдлын үед	16.0	Улсын төсөв	Тоо	Чингэлтэй дүүргийн 49,50,57,117-р сургууль нийт 4 байршилд 4 улсын байцаагч урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж шинжилгээ авах байруудыг бэлдүүлж, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажилласан.	Цэгүүдэд ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт 100% хийлгүүлж, гадна орчинд хүн хоорондын зай баруулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлсэн байна	4.0	Цэгүүдэд ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт 100% хийлгүүлж, гадна орчинд хүн хоорондын зай баруулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлсэн байна	4.0	Цэгүүдэд ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт 100% хийлгүүлж, гадна орчинд хүн хоорондын зай баруулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлсэн байна	4.0	Цэгүүдэд ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт 100% хийлгүүлж, гадна орчинд хүн хоорондын зай баруулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлсэн байна	4.0	МХХ	ЭМТ	

1.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.	1.1.5. Хүнсний үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хадгалалт, түүгээлт, ундны ус, түүгээх байруудын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, эрүүл ахуй, халдвар хамгааллын даглэмийг хангаж ажиллаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт хийж, халдвараас урьдчилан сэргийлэх сурталчилгаа зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.	Цар тахлын бэлэн байдлын үед	21.0	Улсын төсөв	тоо	Чингэлтэй дүүргийн хэсгийн болон зөвөрийн усан хангамжтай 155, 174, 222, 246, 221, 220, 224-р цэцэрлэг, 117, 138, 139, 140-р сургуулийн ундны ус нөөцлөх савыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх чиглэл зааварчилгаа өгч, гүйцэтгэлийг шалган, унд ахуйн уснаас нийт 28 сорьц, дээж авч НМХГ-ын Төв лабораторит хургүүлэн, шинжилгээний дүнг үндэслэн 23 дүгээлт үйлдсэн Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын байцаагчид орон нутаг зорчих хүсэлтэй иргэдийн шинжилгээ өгөх 2 цэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж шинжилгээ авах байруудыг бэлдүүлж, халдвар хамгааллын дэглэм хяналт тавьж байна. Шинжилгээнд 4617 иргэн хамрагдсан байна. Тус цэгүүдэд ариутгал цэвэрлэгээг 2 цаг тутамд хийлгэж, 101 удаа 5194 м.кв талбайд халдваргүйжүүлэлт хийлгүүлж, гадна орчинд хүн хоорондын зай бариулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллалав. Нийт 112 удаа сорьцыг тээвэрлүүлэв.	Хүнсний аюулгүй үйлдвэрлэх нөхцөл шаардлага хангагдана.	6.0	Хүнсний аюулгүй үйлдвэрлэх нөхцөл шаардлага хангагдана.	5.0	Хүнсний аюулгүй үйлдвэрлэх нөхцөл шаардлага хангагдана.	5.0	Хүнсний аюулгүй үйлдвэрлэх нөхцөл шаардлага хангагдана.	5.0	MXX	ХХҮХ			
	1.2.1. Коронавируст халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, эмнэлгүүдэд ажиллаж буй коронавируст халдвар /КОВИД-19/-ын түргэвчилсэн оношилгооны цэгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Цар тахлын бэлэн байдлын үед	9.0	Улсын төсөв	тоо	2020 онд зохион байгуулсан сургалтуудаар өмнөх онд зохион байгуулсан сургалт болон сургалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчдын тоог 10% -аас доошгүй хувиар нэмэгдүүлсэн.	Бэлэн байдлын зэрэг 100% хангагдана	3.0	Бэлэн байдлын зэрэг 100% хангагдана	2.0	Бэлэн байдлын зэрэг 100% хангагдана	2.0	Бэлэн байдлын зэрэг 100% хангагдана	2.0	MXX	ЭМТ			
	1.2.2. Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулна.	Цар тахлын бэлэн байдлын үед	9.0	Улсын төсөв	тоо	Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнуудын хууль тогтоомжийн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хандах хандлага сайжирч эрсдэл буурна	Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнуудын хууль тогтоомжийн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хандах хандлага сайжирч эрсдэл буурна	3.0	Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнуудын хууль тогтоомжийн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хандах хандлага сайжирч эрсдэл буурна	2.0	Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнуудын хууль тогтоомжийн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хандах хандлага сайжирч эрсдэл буурна	2.0	Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнуудын хууль тогтоомжийн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хандах хандлага сайжирч эрсдэл буурна	2.0	MXX	ХХҮХ			
1.3. Халдварт цар тахлын эрсдэл нэмэгдэхээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангах, түүнд зарцуулах төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	1.3.1. Засаг даргын нөөц сангийн бэлэн байдлыг хангах, бусад нөөцийн судалгааг цагийн байдалд тохируулан хурдан шуурхай хийж гүйцэтгэнэ.	Цар тахлын бэлэн байдлын үед	2000.0	-	төгрөг	500.0	500.0	-	500.0	-	500.0	-	500.0	-	500.0	-	ТЗУХ, СТСХ	ОБХ	Нийт төсөт байгууллага уд.иргэд олон нийт
1.4. Цар тахлын тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагааныг бэлэн байдалд оруулах ажлыг хэрэгжүүлнэ.	1.4.1. Дүүргийн зорилтот хүн ам болон нэн шаардлагатай албан хаагчдыг "Ковид-19"-ийн дархлаажуулалтад бүрэн хамруулна.	Цар тахлын бэлэн байдлын үед	Батлагдсан төсвийн хүрээнд	Улсын төсөв	Хувь	0	100%	-	100%	-	100%	-	100%	-	100%	-	HXX,	ЭМТ, ОБХ	ТЗУХ
	1.4.2. Цар тахлын халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, нөөцийг хангах, тандалт, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлнэ.	Цар тахлын бэлэн байдлын үед	2170.0	Улсын төсөв	Төсөв	170 сая	100%	500.0	100%	500.0	100%	500.0	100%	500.0	100%	500.0	100%	ДОК	НОК

Хариу арга хэмжээний үзэл баримтлал хангаж, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан вакцинаар хангах асуудлаар холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллана.	11	1.4.3 Цар тахлын тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан вакцинжуулалтын явцад вакцины хадгалалт, тээвэрлэлт, вакцинжуулалтын үеийн халдвар хамгааллын байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Цар тахлын бэлэн байдлын үед	8.0	Улсын төсөв	Хувь	-	Вакцин тээвэрлэлт, вакцинжуулалтын үеийн бэлтгэл бэлэн байдал 100% хангагдана.	2.0	Вакцин тээвэрлэлт, вакцинжуулалтын үеийн бэлтгэл бэлэн байдал 100% хангагдана.	2.0	Вакцин тээвэрлэлт, вакцинжуулалтын үеийн бэлтгэл бэлэн байдал 100% хангагдана.	2.0	Вакцин тээвэрлэлт, вакцинжуулалтын үеийн бэлтгэл бэлэн байдал 100% хангагдана.	2.0	МХХ	ЭМТ	
	1.5.1 Их дээд сургууль, Ерөнхий боловсролын сургуулийн оюутны дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	12	Цар тахлын бэлэн байдлын үед	4.0	Улсын төсөв	Хувь	-	100%	1.0	100%	1.0	100%	1.0	100%	1.0	100%	МХХ	БХ
1.5. Халдварын улмаас сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тогтоож, боловсролд зориулсан зардлыг урьдчилан тооцно.	13	1.5.2. Халдварын улмаас сургууль завсардалтад өргөж болзошгүй сурагчдын судалгаа хийн нэгтгэж, холбогдох байгууллагад хүргүүлж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Цар тахлын бэлэн байдлын үед	-	-	Тоо /судалгаа/	1	1	-	1	-	1	-	1	-	БХ	НХХ, БХ, СТСХ	
	1.6.1. Хүнсээр хангах мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ.	14	Цар тахлын бэлэн байдлын үед	-	-	Тоо /Хүнс ханган нийлүүлэх гэрээ хийх ААНБ/	Хүнс ханган нийлүүлэхээр 27 байгууллагатай гэрээ байгуулсан.	50	-	60	-	70	-	80	-	ХХҮХ	НЗАА	
1.6 Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад иргэд, аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн дэмжлэг, туслацааг нэмэгдүүлэх чиглэлээр олон төрлийн арга хэмжээг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.	15	1.6.2. Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.	Цар тахлын бэлэн байдлын үед	-	-	Тоо /Хамрагдсан ААНБ/	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг худалдаа үйлчилгээний 981, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 385, ахуй үйлчилгээний 721, авто үйлчилгээний 146, хүнсний үйлдвэрийн чиглэлээр 45 нийт 2278 байгууллага, үйлчилгээний газруудад ариутгал, халдваргүйжүүлэлтийг хуваарийн дагуу тогтмол хийлгэсэн.	-	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг нийт ААНБ-уудад хяналт тавьж ажилласан байна.	-	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг нийт ААНБ-уудад хяналт тавьж ажилласан байна.	-	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг нийт ААНБ-уудад хяналт тавьж ажилласан байна.	-	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг нийт ААНБ-уудад хяналт тавьж ажилласан байна.	-	ХХҮХ	МХХ
	Нийт шаардлагатай хөрөнгө:			4250.0					528.0		525.0		525.0		525.0			

ХОЁР. ХҮНИЙ ХӨРГЖЛИЙН БОДЛОГО

2.1. ЭРҮҮЛ МЭНД																	
2.1.1. Хүн амын халдварт болон халдварт бус өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх "Эрүүл Чингэлтэйчүүд-2024" арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	16	2.1.1.1. "Эрүүл Чингэлтэйчүүд-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	2021-2024	2,500.0	Дүүргийн төсөв	Хувь	0	25%	700.0	50%	600.0	75%	600.0	100%	600.0	НХХ	ЭМТ
	2.1.2. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эмчилгээ, оношилгооны хүчин чадал, нэр төрлийг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг үе шаттайгаар сайжруулж, ажилтан, албан хаагчдын хариуцлага, урамшууллын тогтолцоог шинэчилнэ.	17	2.1.2.1. Дүүргийн хэмжээнд дурангийн мэс заслын үйлчилгээг нэвтрүүлж тусламжийн нэр төрлийг нэмэгдүүлнэ. (Дурангийн мэс заслын иж бүрдэл Endoscopic Surgical System нэвтрүүлэх/	2021-2024	300.0	Дүүргийн төсөв	Тоо /дурангийн мэс засал/	0	-	-	20	300.0	40	-	60	-	ЭМТ
18		2.1.2.2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж дүүргийн эрүүл мэндийн төвийн эмчилгээ, оношилгоо яаралтай тусламж үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	2000.0	Дүүргийн төсөв	Хувь	0	-	-	50%	1000.0	75%	500.0	100%	500.0	ЭМТ	НХХ

2.1.3. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, Хайлааст салбар Амбулатори-2, Жишиг Эрхийн Эрүүл мэндийн төвүүдийн барилгыг барих ажлыг даад шатны байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.	19	2.1.3.1. Дүүргийн Нэгдсэн эмнэлэг барих талаар НЭМГ, АХБ-ны "ЭМСХХ-6" төслийн багтай хамтран зөвшилцөх уулзалт хийж гарсан саналыг боловсруулж НЭМГ-аар уламжлуулан Нийслэлийн газар зохион байгуулах албаны газар чөлөөлөх албанд Албан ёсоор хандаж эмнэлэг баригдах газрын асуудлыг тавих ЧДЭДТГ, ЧДИТХ-аар газрын асуудлыг НИТХ-аар хэлэлцүүлэн газрын асуудлыг шийдвэрлэнэ.	2021-2022	Урьдчилсан тооцоогоор эмнэлэг барих газарт нийт 2,6 га газрыг (26'000м2) 1 метр квадрат газрын үнийг 1153847-өөр тооцоход 3 тэрбум төгрөг шаардлагатай	Улсын төсөв	Хувь	0	-	-	-	70%	2,001 0	100%	900.0	HXX	ТГХШХ	ЭМТ	
	20	2.1.3.2. Дүүргийн 13 дугаар хороонд баригдах буй салбар амбулаторийн барилгын гүйцэтгэлд зохих хяналтыг тавьж, хамтран ажиллах. Шинээр баригдах буй Хайлааст салбарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	2021-2022	Нийт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хогшлын зардал 2.5 тэрбум төгрөг	Улсын төсөв 1.5 тэрбум, дүүргийн төсөв 1 тэрбум	Хувь	10%	70%	1,750 0	100%	750 0	-	-	-	ЭМТ	HXX	ЭМТ	
	21	2.1.3.3. Хороодод шинээр баригдах өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хэрэгцээг тодорхойлж, жишиг ЭӨМТ-ийн тоог нэмэгдүүлнэ.	2020-2024	АХБ-ны загвар ЭӨМТ-5 тэрбум, Нийслэлийн жишиг ЭӨМТ 6 тэрбум нийт 11 тэрбум	Улсын төсөв 5 ЭӨМТ нийт 6 тэрбум төгрөг, Гадаадын шууд хөрөнгө оруулалт АХБ-ны загвар ЭӨМТ-5 тэрбум	Тоо	Тоо	5	2	2,400 0	1	1,200 0	1	5,000 0	2	1,200 0	ЭМТ	ЗДТГ
2.1.4. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, үйл ажиллагааны явцыг бүрэн цахимжуулж, эмчилгээ, үйлчилгээнд орчин үеийн технологийн дэвшлүүдийг ашиглах замаар цахим эрт илрүүлэг, эргэн дуудах болон эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлэхэд холбогдох дэмжлэг үзүүлнэ.	22	2.1.4.1. Эрүүл мэндийн цахим нэгдсэн сангийн хагдалалт, хамгаалалтыг сайжруулах, серверүүдийг шинэчилнэ.	2021-2022	200 0	Дүүргийн төсөв	Тоо	0	3	150 0	2	50 0	-	-	-	ЭМТ	HXX	ЭӨМТ	
	23	2.1.4.2. Ehealth програм хангамжид тулгуурласан эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор бүртгэл мэдээллийг чанаржуулна.	2021-2024	135 0	Дүүргийн төсөв	Тоо	30%	50%	30 0	70%	45 0	90%	60 0	100%	-	ЭМТ	HXX	ЭӨМТ
	24	2.1.4.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд орчин үеийн технологийн дэвшлүүдийг ашиглах замаар цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	2021-2024	150 0	Дүүргийн төсөв	Хувь	30%	70%	60 0	70%	100 0	90%	150 0	100%	-	ЭМТ	HXX	ЭӨМТ
2.1.5. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг дэмжин ажиллана.	25	2.1.5.1. Эрүүл мэндийн мобайл технологийн их бүрдэлтэй ЭӨМТ-үүдийн тоог нэмэгдүүлэх, эрт илрүүлгийг сайжруулна.	2021-2024	300 0	Улсын төсөв, Нийслэлийн төсөв	Тоо	6	2	120 0	1	60 0	1	60 0	1	60 0	ЭМТ	HXX	ЭӨМТ
	26	2.1.5.2. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүдийг бэлтгэн ажиллуулах, тогтвортой ажиллагааг дэмжинэ.	2021-2024	100 0	Дүүргийн төсөв	Тоо /сайн дурын ажилтны тоо/	40	60	25 0	80	25 0	100	25 0	120	25 0	ЭМТ	HXX, ИТХ	ЭӨМТ
	27	2.1.5.3. "Эрүүл" иргэн, өрх, байгууллага хамт олныг шалгаруулах, сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулна.	2021-2024	100 0	Дүүргийн төсөв	Тоо	3	10	25 0	10	25 0	10	25 0	10	25 0	ЭМТ	HXX	ЭӨМТ
	28	2.1.5.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах мэдээлэл сургалт сурталчилгааг өргөжүүлнэ.	2021-2024	100 0	Дүүргийн төсөв	Тоо /Хамрагдсан иргэд/	50000	65000	25 0	80000	25 0	90000	25 0	100000	25 0	ЭМТ	HXX	ЭӨМТ
Шаардлагатай хөрөнгө				22385 0					5285 0		4180 0		8446 0		3335 0			
2.2. БИЕИЙН ТАМИР, СПОРТ																		

2.4.1. Иргэдийг ажлын байраар хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой "Бүтээлч Чингэлтэйчүүд-2024" арга хэмжээг уламжлал болгон хэрэгжүүлнэ.	39	2.4.1.1. "Бүтээлч Чингэлтэйчүүд-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулал дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	2021-2024	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хувь	-	25%	50%	75%	100%		ХХҮХ	БИТ					
2.4.2. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох бодлогыг дэмжин ажиллана.	40	2.4.2.1. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд LMS программ шинэчлэлд санал оруулж иргэдийн мэдээллийг бүртгэн мэдээллийг хүргэнэ.	2021-2024	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Тоо /хамрагдсан иргэд/	3000	3500	-	4000	-	4500	-	5000	ХөҮҮХ				
	41	2.4.2.2. "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд E.Halamj програмын шинэчлэл хийгдэж иргэдийн мэдээллийг бүртгэн халамжийн үйлчилгээг цахим болгоно.	2021-2024	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Тоо /иргэдэд үзүүлэх үйлчилгээг /	6	6	-	6	-	6	-	6	ХөҮҮХ				
2.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч дээ бүтэц, тохижилт, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.	42	2.4.3.1. ОНОТХУ-ний нийгмийн халамжийн дэмжлэг туслацгаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх хамт олны бүлэг бүрдүүлэх орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх амьдрах ухаанд сурлана.	2021-2024	16.0	Дүүргийн төсөв	Тоо /бүлэг/	8	8	4.0	8	4.0	8	4.0	8	4.0	Жилдээ	ХөҮҮХ		
	43	2.4.3.2. Дүүргийн хэмжээнд хөтөцтэй явган замын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021-2024	193.5	Улсын төсвийн 95.4 сая төгрөг, нийслэлийн төсвийн 55.1 сая төгрөг, дүүргийн төсвийн 43 сая төгрөг	M2	45000M2	800M2	36.0	900M2	40.5	1100M2	49.5	1500M2	67.5	ТНААХ	НХХ		
	44	2.4.3.3. Дүүргийн хэмжээнд барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шатыг нэмэгдүүлнэ.	2021-2024		Батлагдсан төсвийн хүрээнд	-	у/м	1424	Барилга байгууламжийн орчимд 10% нэмэгдүүлнэ	-	Барилга байгууламжийн орчимд 10% нэмэгдүүлнэ	-	Барилга байгууламжийн орчимд 10% нэмэгдүүлнэ	-	Барилга байгууламжийн орчимд 10% нэмэгдүүлнэ	-	ТНААХ	НХХ	
2.4.4. Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн дотоод гадаад төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллана.	45	2.4.4.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	2021-2024		Батлагдсан төсвийн хүрээнд	-	Тоо /Хамрагдсан иргэд/	360	450	-	500	-	580	-	650	-	ХөҮҮХ	НХХ	
	46	2.4.4.2. Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021-2024		Батлагдсан төсвийн хүрээнд	-	Тоо /Хамрагдсан өрх/	530	530	-	530	-	530	-	530	-	ХөҮҮХ	НХХ	
2.4.5. Нийгмийн даатгалын тухай хувь тогтоомжийн хэрэгжилтийг	47	2.4.5.1. Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын тайланг тоон гарын үсгээр илгээх ажлыг сурталчлан зохион байгуулах, тоог нэмэгдүүлэх, цахим энцэт /http://10.9.0.5/monitoring/ -ыг сайжруулах	2021-2024			Хувь /хамрагдсан иргэд/		4,885,827,023.96 төгрөгний цалингийн сан бүхий 213 аж ахуйн нэгж байгууллагыг нийгмийн даатгалд шинээр бүртгэж, албан журмын даатгалд 1403 даатгуулагчийг шинээр хамруулсан	100	-	100	-	100	-	100	-	НДХ	НХХ	

Хангах хүн амд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	48	2.4.5.2. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний аппликейшныг даатгуулагчийн гар утсанд суулгах, сайн дурын даатгалын гэрээг аппликейш ашиглан цахимаар байгуулах, сунгах талаар зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж, аппликейшны хэрэглээг нэмэгдүүлэх, шимтгэл төлөлтийн талаарх архивын лавлагааг 4500 гаруй иргэд даатгуулагчдад цахимаар /QR кодтой/ олгож хэвшинэ.	2021-2024	-	-	Хувь /Хамрагдсан иргэд/	2020 онд аппликейшныг нийт 2500 гаруй, сайн дурын даатгалын гэрээг аппликейш ашиглан цахимаар байгуулан сунгасан. Шимтгэл төлөлтийн лавлагааг 4500 гаруй иргэд даатгуулагчдад цахимаар /QR кодтой/ олгосон.	100	-	100	-	100	-	100	-	НДХ	НХХ	0
Шаардлагатай хөрөнгө:			209.5					40		44.5		53.5		71.5				

2.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛ

2.5.1. Гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Гэр бүл-2024" арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиглана.	49	2.5.1.1. "Гэр бүл-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиглана.	2021-2024 он	Батлагдсан төсвийн хүрээнд	-	Хувь	2020 оны суурь түвшин	25%	-	50%	-	75%	-	100%	-	НХХ,	ГБХЗХХ,	ХөХҮХ
2.5.2. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх төвийг байгуулна.	50	2.5.2.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд Гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулан үйлчилгээ үзүүлнэ.	2021-2024 он	Батлагдсан төсвийн хүрээнд	Дүүргийн төсөв	Тоо /Хамрагдсан хүүхдийн тоо/	24	Урт хугацааны төлөвлөгөө боловсруулан батлуулж шат дарваатай арга хэмжээнийг авч ажиллах. Жилд 80 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	160 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	240 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	320 хүүхдэд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ болон хууль эрх зүйн тусламж, боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	ГБХЗХХ	НХХ	
	51	2.5.2.2. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэнд сэтгэлзүйн болон хөгжлийн үйлчилгээний шаардлага хэрэгцээг судлах сэтгэлзүйн баг байгуулна.	2021-2024 он	Батлагдсан төсвийн хүрээнд	Дүүргийн төсөв	Хувь /Хамрагдсан иргэд/	-	Сэтгэлзүйн баг байгуулсан байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдийн 70%-д хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдийн 100%-д хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдийн 100%-д хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Гэр бүлийн хүчирхийллийн тоо буурсан байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдэд 100% хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	ГБХЗХХ	НХХ	Хороод
2.5.3. Асрамжийн газарт өсөж, 18 нас хүрсэн залуучуудыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх төсөлд камруулна.	52	2.5.3.1. Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлж МСУТ болон холбогдох сургалтын төвүүдэд холбон зуучилж, түр болон байнгын ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.	2021-2024 он	Батлагдсан төсвийн хүрээнд	Дүүргийн төсөв	Хувь /Хамрагдсан иргэд/	2	Асрамжийн газарт өсч, 18 нас хүрсэн Чингэлтэй дүүргийн харьяатай 5 залууд бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлсэн байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст 100% хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст 100% хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарсан залуус амьдрах ухаанд суралцан боловсрол, мэргэжилтэй болсон байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	ГБХЗХХ	НХХ	
Шаардлагатай хөрөнгө				Батлагдсан төсвийн хүрээнд					Батлагдсан төсвийн хүрээнд		Батлагдсан төсвийн хүрээнд		Батлагдсан төсвийн хүрээнд		Батлагдсан төсвийн хүрээнд			

2.6. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ

2.6.1. Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн агуулгыг баяжуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой "Соёлтой иргэн-2024" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	53	2.6.1.1. "Соёлтой иргэн-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиглана.	2021-2024	Батлагдсан төсвийн хүрээнд	-	хувь	0%	25%	-	50%	-	75%	-	100%	-	НХХ	БХ	Соёлын төв
2.6.2. Үндэсний бахархал өв соёлыг иргэдэд түгээн дэлгэрүүлж, соёл урлагийн үйлчилгээгээр дамжуулан сурталчлан таниулах, иргэд олон нийтэд хүргэж, тэдэнд үйлчлэх тав тухтай орчныг бий болгож, "Соёлын ордон барих" ажлыг эхлүүлнэ.	54	2.6.2.1. Үндэсний бахархал өв соёлыг иргэдэд түгээн дэлгэрүүлж, соёл урлагийн үйлчилгээгээр дамжуулан сурталчлан таниулах, иргэд олон нийтэд хүргэж, тэдэнд үйлчлэх Соёлын ордон барина.	2021-2022	Батлагдсан төсвийн хүрээнд	-	хувь	Соёлын ордны барилгын зураг төслийг Балданс ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн	30%	-	70%	-	100%	-	-	-	НХХ	СТ	

2.6.3 Соёл, урлагийн тогтвортой мөхлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлнэ	55	2.6.3.1 "Эрдийн задгай театр"-т соёлын үйлчилгээг иргэдэд хүргэнэ	2021-2024	15.5	Дүүргийн төсөв	Тоо /Хамрагдсан иргэд/	-	500	3.5	500	4.0	500	4.0	500	4.0	СТ	HXX		
	56	2.6.3.2 Соёлын биет бүс өв хэргийг болон ахмад уран бүтээлчийн авъяас,ур чадварыг өвлүүлэн дамжуулах, таниулан сурталчлана	2021-2024	6.0	Дүүргийн төсөв	Тоо /Хамрагдсан иргэд/	-	800	1.5	800	1.5	800	1.5	800	1.5	800	1.5	СТ	HXX
	57	2.6.3.3 Соёлын төвийн дуурайлангийн сургагчдын тайлан тоглолт зохион байгуулна	2021-2024	4.0	Дүүргийн төсөв	Тоо /Хамрагдсан сургагчид/	-	25	1.00	25	1.00	25	1.00	25	1.00	25	1.00	СТ	HXX
Шаардлагатай хөрөнгө:				25.5				6.00		6.50		6.50		6.50		6.50			
Нийт шаардлагатай хөрөнгө:				27357.6				6470.40		5400.40		9895.40		4602.00					

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1 САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1.1. Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ахлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана	58	3.1.1.1 Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил тод, нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ	2021-2024			Хувиар	94.58%	Төлөвлөгөө 100 ба түүнээс дээш хувиар биелүүлсэн байх, зардлыг үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх		Төлөвлөгөө 100 ба түүнээс дээш хувиар биелүүлсэн байх, зардлыг үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх		Төлөвлөгөө 100 ба түүнээс дээш хувиар биелүүлсэн байх, зардлыг үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх		Төлөвлөгөө 100 ба түүнээс дээш хувиар биелүүлсэн байх, зардлыг үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх		CTCX	TX
	59	3.1.1.2 Дүүргийн төсвийн орлого, зарлагын төсвийн төслийг боловсруулах, санал авах, тодорхойлох, судалгаа, тооцоо хийж, төсвийн төслийг хуулийн дагуу өргөн барьж, хэлэлцүүлэх, батлуулах, хэрэгжүүлнэ	2021-2024					Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй, бодитой төлөвлөсөн байх		Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй, бодитой төлөвлөсөн байх		Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй, бодитой төлөвлөсөн байх		Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй, бодитой төлөвлөсөн байх		CTCX	TX
3.1.2 Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийн, төсвийн сахилга хариуцлага, дүүргийн төсвийн байгууллагуудын орлого, зарлага хөрөнгө оруулалтын ажил болон хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна	60	3.1.2.1 Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хяналт тавих ажлыг тогтмолжуулан, төсвийн сахилга хариуцлага, үр ашиг, тайлагнал, ил тод нээлттэй байдлыг хангана	2021-2024	10.0	Дүүргийн төсөв	Хувь		Зардлыг бодитой төлөвлөх, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тодорхойлж, төсвийг үр ашигтай зарцуулсан байх	10.0	Зардлыг бодитой төлөвлөх, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тодорхойлж, төсвийг үр ашигтай зарцуулсан байх	Батлагдсан төсвийн хүрээнд	Зардлыг бодитой төлөвлөх, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тодорхойлж, төсвийг үр ашигтай зарцуулсан байх	Батлагдсан төсвийн хүрээнд	Зардлыг бодитой төлөвлөх, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тодорхойлж, төсвийг үр ашигтай зарцуулсан байх	Батлагдсан төсвийн хүрээнд	CTCX	НТАГазар, төсөвт байгууллагууд
3.1.3 Монгол Улсын татварын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх талаар дэмжиж ажиллана	61	3.1.3.1 Монгол Улсын татварын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх талаар дэмжиж ажиллана	2021-2024	160.0	Дүүргийн төсөв	Хувь	100%	100%	40.0	100%	40.0	100%	40.0	100%	40.0	TX	
3.1.4 Дүүргийн өмч хөрөнгийн ашиглалтын менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ	62	3.1.4.1 Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулан, өмч хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг дээшлүүлэн ажиллана	2021-2024	4.0	Дүүргийн төсөв	Хувь	95 хувь	Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, бүртгэлгүй өмч хөрөнгийг эзэнжүүлэн орон нутгийн өмч хөрөнгийн мэдээллийн сан баяжуулан ажиллах	1	Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, бүртгэлгүй өмч хөрөнгийг эзэнжүүлэн орон нутгийн өмч хөрөнгийн мэдээллийн сан баяжуулан ажиллах	1	Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, бүртгэлгүй өмч хөрөнгийг эзэнжүүлэн орон нутгийн өмч хөрөнгийн мэдээллийн сан баяжуулан ажиллах	1	Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, бүртгэлгүй өмч хөрөнгийг эзэнжүүлэн орон нутгийн өмч хөрөнгийн мэдээллийн сан баяжуулан ажиллах	1	CTCX	Нийслэлийн өмчийн харилцааны газар,Тохижилт нийтийн аухайн хэлтэс, ТҮК ХХК,

	63	3.1.4.2. Дүүргийн өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт өгч эсрэдлийн удирдлагаар ханган зөөлөмж өгч ажиллана.	2021-2024	Батлагдсан төсвийн хүрээнд	Дүүргийн төсөв	Хувь	100%	100%	Батлагдсан төсвийн хүрээнд	100%	Батлагдсан төсвийн хүрээнд	100%	Батлагдсан төсвийн хүрээнд	100%	Батлагдсан төсвийн хүрээнд	ДАА	НҮА	ЗДТГ
3.1.5. Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд, хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай зарчмуудыг баримтлан 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүн, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй мэдээлнэ.	64	3.1.5.1. Тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан зохион байгуулж, үр дүн, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэнэ.	2021-2024	-	-	Хувь	2020 онд 52 ажиллагааг www.tender.gov.mn-ээр дамжуулан зохион байгуулсан.	Худалдан авах ажиллагаа 100% хийгдсэн байна	-	Худалдан авах ажиллагаа 100% хийгдсэн байна	-	Худалдан авах ажиллагаа 100% хийгдсэн байна	-	Худалдан авах ажиллагаа 100% хийгдсэн байна	-	XAAA	-	-
3.1.6 Статистикийн тоон мэдээллийн хэрэгсэл, ашиглалтыг сайжруулж, үнэн зөв байдлыг ханган, мэдээ судалгааны хамрах хүрээг өргөжүүлнэ.	65	3.1.6.1. Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр "Статистикийн эмхэтгэл-2019", "Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга" "Өрх, хүн амын танилцуулга", "Иргэдийн эрүүл мэндийн судалгаа", "Боловсролын судалгаа", "Оршин суугчдын аюулгүй байдлын судалгаа", "Орон сууцны нөхцөл байдлын судалгаа", зэргийг эмхэтгэн гаргаж, нээлттэй тархаана.	2021-2024	Батлагдсан төсвийн хүрээнд	Нийслэлийн төсөв	тоо	600	"Статистикийн эмхэтгэл-2020"-ийг 30 ширхэг "Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга" сар бүр 30 ширхэг нийт 360, бусад 11 төрлийн судалгаа танилцуулгыг нийт 360 ширхгийг хэвлэж тархаана.	Нийслэлийн төсөв	"Статистикийн эмхэтгэл-2021"-ийг 30 ширхэг "Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга" сар бүр 30 ширхэг нийт 360, бусад 11 төрлийн судалгаа танилцуулгыг нийт 360 ширхгийг хэвлэж тархаана.	Нийслэлийн төсөв	"Статистикийн эмхэтгэл-1992-2022"-ийг 50 ширхэг "Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга" сар бүр 30 ширхэг нийт 360, бусад 11 төрлийн судалгаа танилцуулгыг нийт 360 ширхгийг хэвлэж тархаана.	Нийслэлийн төсөв	"Статистикийн эмхэтгэл-2023"-ийг 30 ширхэг "Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга" сар бүр 30 ширхэг нийт 360, бусад 11 төрлийн судалгаа танилцуулгыг нийт 360 ширхгийг хэвлэж тархаана.	Нийслэлийн төсөв	СХ	Дэргэдэх хэлтэс, албад, хороод	ААНБ
	66	3.1.6.2. Хүн ам, өрхийн мэдээллийн санг баяжуулж, мэдээллийн чанарыг сайжруулна.	2021-2024	Батлагдсан төсвийн хүрээнд	Нийслэлийн төсөв	хувь	94.5	96	Нийслэлийн төсөв	97	Нийслэлийн төсөв	98	Нийслэлийн төсөв	99	Нийслэлийн төсөв	СХ	ЗДТГ, хороод	иргэд
	67	3.1.6.3. Аж ахуй нэгж, байгууллагын 2021 оны улсын ээлжит тооллого зохион байгуулна.	2021 он	Батлагдсан төсвийн хүрээнд	Нийслэлийн төсөв	Хувь	96.1	100	Нийслэлийн төсөв	-	-	-	-	-	-	СХ	ЗДТГ, хэлтэс албад, хороод	ААНБ
Шавардлагатай хөрөнгө:				174.0					51.0		41.0		41.0		41.0			
3.2. ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ																		
3.2.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих "Чингэлтэйд үйлдвэрлэв-2024" арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	68	3.2.1.1 "Чингэлтэйд үйлдвэрлэв-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	2021-2024	264.8	Дүүргийн төсөв	Хувь	Чингэлтэйд үйлдвэрлэв 2020 дэд хөтөлбөр 84.2 хувьтай хэрэгжсэн.	25%	66.2	50%	66.2	75%	66.2	95%	66.2	ХХҮХ	БИТ	
